



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/87/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/149
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020779
D 2022/2022 он / ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,983,275.36	186,367,094.36
33	АВЛАГА	13,900,000.00	45,000,000.00
335	Бусад авлага	13,900,000.00	45,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,900,000.00	45,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	122,083,275.36	141,367,094.36
351	Түүхий эд материал	18,473,880.00	25,976,040.00
35110	Тусгай зориулалттай материал	18,473,880.00	25,976,040.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,072,470.00	11,072,470.00
354	Хангамжийн материал	67,588,592.56	77,371,917.56
35410	Бичиг хэргийн материал	188,000.00	148,000.00
35420	Аж ахуйн материал	14,133,760.00	12,373,760.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,828,400.00	1,773,300.00
35440	Түлш, шатах тослох материал	1,897,900.00	-
35460	Хүнсний материал	1,440,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	43,100,532.56	63,076,857.56
35600	Мал амьтад	24,948,332.80	26,946,666.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	953,670,306.51	1,268,814,258.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	953,670,306.51	1,268,814,258.52
392	Биет хөрөнгө	940,199,306.51	1,255,409,258.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	915,739,584.92	1,108,688,396.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(288,009,987.07)	(329,042,412.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	231,101,451.20	283,390,420.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(167,787,999.96)	(150,092,475.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	409,799,262.78	391,460,068.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(264,368,654.51)	(264,768,178.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,245,667.69	47,009,251.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,545,781.87)	(42,222,551.92)
39209	Зам, гүүрийн байгууламж	64,200,000.00	64,200,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(64,200,000.00)	(64,200,000.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,610,800.00	10,610,800.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,065,887.13	221,026,863.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,650,923.80)	(20,650,923.80)
393	Биет бус хөрөнгө	13,471,000.00	13,405,000.00
39301	Програм хангамж	2,127,500.00	2,127,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(390,500.00)	(456,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,734,000.00	11,734,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,089,653,581.87	1,455,181,352.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	224,539.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	224,539.00
413	Өглөг	-	224,539.00
4136	Бусад өглөг	-	224,539.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	199,584.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	24,955.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,089,653,581.87	1,454,956,813.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,089,653,581.87	1,454,956,813.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	526,982,283.38	526,982,283.38
51101	Өмч: - төрийн	526,982,283.38	526,982,283.38
512	Хуримтлагдсан үр дүн	417,969,035.49	783,272,267.50
51210	Өмнөх үеийн үр дүн	417,969,035.49	417,969,035.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	365,303,232.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	144,702,263.00	144,702,263.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,089,653,581.87	1,455,181,352.88

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,717,519.90	1,380,599,924.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,483,662.00	110,325,628.00
120	Нийтлэг татварын бус орлого	83,483,662.00	110,325,628.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	638,233,857.90	1,270,274,296.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,035,657.90	92,489,096.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	66,035,657.90	92,489,096.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	572,198,200.00	1,177,785,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	572,198,200.00	1,177,785,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	743,236,004.92	993,114,489.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	688,436,004.92	850,093,489.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,733,634.42	795,505,141.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,851,299.00	288,378,777.00
210101	Үндсэн цалин	172,527,062.00	179,693,795.00
210102	Нэмэгдэл	48,585,952.00	53,060,962.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,738,285.00	55,624,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,870,778.40	39,096,493.60
210201	Тэтгэврийн даатгал	22,482,278.40	27,558,897.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,967,800.00	2,900,898.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,157,000.00	2,320,699.35
210204	Ажилгүйдлийн даатгал	569,400.00	580,097.96
210205	Эрүүл мэндийн даатгал	5,694,300.00	5,735,899.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,100,629.00	94,412,339.00
210301	Гэрэл, цахилгаан	8,806,929.00	12,715,984.00
210302	Түлш, халаалт	68,293,700.00	81,696,355.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,919,690.00	45,148,538.00
210401	Бичиг хэрэг	3,758,800.00	4,100,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,555,190.00	20,445,718.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,208,700.00	7,149,945.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	11,104,465.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,397,000.00	2,347,510.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,934,000.00	6,664,800.00
210604	Урсгал засвар	6,934,000.00	6,664,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,600,500.00	1,972,500.00
210702	Дотоод албан томилолт	3,600,500.00	1,972,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,933,891.00	6,436,684.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	27,034,261.00	2,994,618.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,339,000.00	1,350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	1,216,066.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,630.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,522,847.02	313,395,009.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,534,400.00	217,369,376.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,988,447.02	96,025,633.16

**Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,702,370.50	54,588,347.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	2,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	2,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,802,370.50	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,802,370.50	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	-	52,188,347.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	52,188,347.77
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,800,000.00	143,021,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,800,000.00	143,021,000.00
221001	Их засвар	40,000,000.00	63,860,000.00
222001	Тоног төхөөрөмж	14,800,000.00	71,514,000.00
223001	Бусад хөрөнгө	-	7,647,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21,518,485.02)	387,485,434.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	22,182,202.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	22,182,202.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(22,182,202.83)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,518,485.02)	365,303,232.01

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	515,248,283.38	144,702,263.00	434,166,258.97	1,094,116,805.35
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	515,248,283.38	144,702,263.00	434,166,258.97	1,094,116,805.35
C07	Тайлант үеийн үр дүн	11,734,000.00	00.00	-16,197,223.48	-4,463,223.48
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	526,982,283.38	144,702,263.00	417,969,035.49	1,089,653,581.87
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	526,982,283.38	144,702,263.00	417,969,035.49	1,089,653,581.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	526,982,283.38	144,702,263.00	417,969,035.49	1,089,653,581.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	365,303,232.01	365,303,232.01
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	526,982,283.38	144,702,263.00	783,272,267.50	1,454,956,813.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	638,233,857.90	1,276,674,296.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	638,233,857.90	1,276,674,296.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,035,657.90	98,889,096.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	66,035,657.90	98,889,096.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	572,198,200.00	1,177,785,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	572,198,200.00	1,177,785,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	577,433,857.90	739,938,042.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	577,433,857.90	739,938,042.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,731,487.40	685,349,694.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,851,299.00	288,378,777.00
210101	Үндсэн цалин	172,527,062.00	179,693,795.00
210102	Нэмэгдэл	48,585,952.00	53,060,962.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,738,285.00	55,624,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,870,778.40	39,096,493.60
210201	Тэтгэврийн даатгал	22,482,278.40	27,558,897.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,967,800.00	2,900,898.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,157,000.00	2,320,699.35
210204	Ажилгүйдлийн даатгал	569,400.00	580,097.96
210205	Эрүүл мэндийн даатгал	5,694,300.00	5,735,899.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,120,629.00	93,696,400.00
210301	Гэрэл, цахилгаан	8,806,929.00	12,516,400.00
210302	Түлш, халаалт	66,313,700.00	81,180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,432,054.00	50,342,510.00
210401	Бичиг хэрэг	3,758,800.00	4,100,900.00
210402	Тээвэр, шатахуун	16,164,554.00	20,445,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,208,700.00	7,149,945.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	15,045,965.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	3,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,510,000.00	6,664,800.00
210604	Урсгал засвар	6,510,000.00	6,664,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,600,500.00	1,972,500.00
210702	Дотоод албан томилолт	3,600,500.00	1,972,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,097,527.00	7,274,517.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	55,197,897.00	3,832,451.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	1,216,066.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	199,630.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,248,700.00	197,923,696.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,248,700.00	197,923,696.63

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,702,370.50	54,588,347.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	2,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	2,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	34,802,370.50	52,188,347.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,802,370.50	52,188,347.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	60,800,000.00	536,736,254.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,800,000.00	536,736,254.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,800,000.00	536,736,254.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,800,000.00	536,736,254.00
221001	Их засвар	4,000,000.00	75,288,510.00
222001	Тоног төхөөрөмж	-	96,514,000.00
223001	Бусад хөрөнгө	-	9,513,294.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,800,000.00	355,420,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(60,800,000.00)	(536,736,254.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	639,885,200.00	612,734,469.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	639,885,200.00	612,734,469.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,885,200.00	610,734,469.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,093,700.00	288,378,777.00
210101	Үндсэн цалин	183,712,100.00	179,693,795.00
210102	Нэмэгдэл	50,580,300.00	53,060,962.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,801,300.00	55,624,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,096,500.00	39,096,493.60
210201	Тэтгэврийн даатгал	27,558,900.00	27,558,897.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,900,900.00	2,900,898.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,320,700.00	2,320,699.35
210204	Ажилгүйдлийн даатгал	580,100.00	580,097.96
210205	Эрүүл мэндийн даатгал	5,735,900.00	5,735,899.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,697,200.00	93,696,400.00
210301	Гэрэл, цахилгаан	12,516,400.00	12,516,400.00
210302	Түлш, халаалт	81,180,800.00	81,180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,460,600.00	50,342,510.00
210401	Бичиг хэрэг	4,100,900.00	4,100,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,445,700.00	20,445,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,864,000.00	7,149,945.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,450,000.00	15,045,965.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	3,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,664,800.00	6,664,800.00
210604	Урсгал засвар	6,664,800.00	6,664,800.00
2107	Томилолт, зочны зардал	8,912,400.00	1,972,500.00
210702	Дотоод албан томилолт	8,912,400.00	1,972,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,790,000.00	3,442,066.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,300,000.00	1,216,066.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,170,000.00	127,140,922.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,170,000.00	127,140,922.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	537,400,000.00	514,988,254.00
2200	Дотоод эх үүсвэрээр	537,400,000.00	514,988,254.00
221001	Их засвар	144,000,000.00	181,748,510.00
222001	Тоног төхөөрөмж	383,400,000.00	323,726,450.00
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00	9,513,294.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,177,285,200.00	1,125,596,852.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,177,285,200.00	1,125,596,852.43
132001	Орон нутгийн төсвөөс	1,177,285,200.00	1,125,596,852.43
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	24.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	96,763,225.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,010,087.00	96,763,225.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,010,087.00	96,363,225.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,769,587.00	3,832,451.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,769,587.00	3,832,451.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,240,500.00	92,530,774.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,240,500.00	92,530,774.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	66,035,657.90	98,889,096.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,035,657.90	98,889,096.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	66,035,657.90	98,889,096.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох е баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 03/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь сумын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийг сайжруулах, хувь хүний чадавх, харилцаа хандлагыг өөрчлөхөд анхаарч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг, дотоод

хяналт зохион байгуулах журмын хамтаар баталсан байна. Тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас өвсний тооцоог шалгасан байна. 12 дугаар сард Аймгийн Засаг даргын үзлэг хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 721,717.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,825.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 8,119.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 20,709.0 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 9,883.2 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 15,531.8 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аймгийн ТЕЗ-ийн хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 1,177,785.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 92,489.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 110,325.6 мянган төгрөг, нийт 1,380,599.9 мянган төгрөг өмнөх оноос 658,882.4 мянган төгрөгөөр буюу 191,3 хувиар өссөн байна.

Зардал:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 993,114.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,276,677.3 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,127,722.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141955001 тоот дансанд 2021 онд 1,315,241.8 мянган төгрөгийн орлого, 1,315,241.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141955408 тоот дансанд 102,070.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 102,070.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	13,900.00	45,000.00	(31,100.00)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	122,083.28	141,367.09	(19,283.82)
Үндсэн хөрөнгө	953,670.31	1,268,814.26	(315,143.95)
Нийт хөрөнгө	1,089,653.58	1,455,181.35	(365,527.77)
Өр төлбөр	-	224.54	(224.54)
Засгийн газрын оролцоо	1,089,653.58	1,454,956.81	(365,303.23)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,089,653.58	1,455,181.35	(365,527.77)

Авлагын дансны үлдэгдэл 45,000.0 мянган төгрөг болж 31,100.0 мянган төгрөгөөр өссөн нь Эрэн хайх, аврах бүлгийн барилгын ажилд 30,000.0 мянган төгрөг, Мандал про аудио ХХК – аас Соёлын төвийн хөгжмийн шинэчлэл хийх ажилд 15,000.0 мянган төгрөг, хил гааль хаалттай байснаас шалтгаалан ажлыг хүлээн аваагүй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 141,367.1 мянган төгрөг болж 19,283.8 мянган төгрөгөөр өссөн нь өвс тэжээл 18,069.0 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын материал 7,502.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,268,814.3 мянган төгрөг болж 365,527.8 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр 433,351.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч, аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 98,728.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,454,956.8 мянган төгрөг болж 365,303.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,207,640.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,207,640.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30,355.4 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 1,177,285.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь тогтмол зардал 17,006.5 мянган төгрөг, цалин, шимтгэлийн зардал 9,758.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 3,471.4 мянган төгрөг тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,177,285.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,177,285.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,177,285.2 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,127,222.8 мянган төгрөгийг зарцуулж, 50,062.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,127,222.8 мянган төгрөг буюу 95,74 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 98,889.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 3,832.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 92,530.8 мянган төгрөг нийт 96,363.3 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 2,125.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны батлагдсан зардлаас Ковид-19 цар тахлын үед 24 цагийн постод ажиллаж буй албан хаагчдын хоолны материалын зардалд, мөн Цар тахлын үед шаардлагатай шатахууны зардал, халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл, ариутгалын бодисын үнэ, хамгаалалтын хувцас, малгай, халад, оношлуур, бээлийний үнэ нийт 18,557.6 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын А/72, А/518 дугаар захирамжаар 7,000.0 мянган төгрөг, иргэдийн хандиваар 22,920.0 мянган төгрөг ирүүлснийг Ковид-19 цар тахлын үед дархлаа дэмжих витаминжуулалтын багц авах зардалд, түргэвчилсэн оношлуурын үнэнд, шатахууны зардалд, халдвар хамгаалалын хэрэгсэл, материалын үнэнд нийт 23,612.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд нийт 433,351.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

1. Барилга байгууламжийн дансанд аймгийн хөрөнгө оруулалтаар 11,582.4 мянган төгрөгөөр гүн өрмийн худаг, сумын төвийн Сэрвэн хорооллын худагт цахим төхөөрөмжийг 8,888.0 мянган төгрөг, ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 7,500.0 мянган төгрөгөөр суурилуулсныг орлого авсан байна. Сумын шилжих үлдэгдлээс нийтийн боловсон нойлын барилгыг 30,000.0 мянган төгрөгөөр, нуурын дэргэд худгийн цооног 10,800.0 мянган төгрөгөөр, ахуй үйлчилгээний төв 77,988.5 мянган төгрөгөөр гүйцэтгэн хүлээн авсан. Мөн ЗДТГ-т ариун цэврийн байгууламж хийгдсэнийг 18,000.0 мянган төгрөгөөр, Цагдаагийн тасгийн засварын ажлыг 10,000.0 мянган төгрөгөөр, Чулуутын 2-р багийн төвийн гадна дотор засварын ажлыг 15,000.0 мянган төгрөгөөр, ахуй үйлчилгээний барилгыг 14,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэснийг тус тус бүртгэн капиталжуулсан нийт 203,758.8 мянган төгрөг байна.
2. Авто тээврийн хэрэгслийн дансанд 19,500.0 мянган төгрөгөөр Цагдаагийн тасагт авто машин, 70,000.0 мянган төгрөгөөр ковш,
3. Тоног төхөөрөмжийн дансанд ЗДТГ-ын албан хаагчдын тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд 10,384.0 мянган төгрөг, гудамжны камерыг нэмэгдүүлэхэд 10,000.0 мянган төгрөг,
4. Тавилга эд хогшлын дансанд 748.0 мянган төгрөгөөр нууцын сейф,
5. Бусад хөрөнгийн дансанд нуурын тохижилтын хашаа 6,000.0 мянган төгрөг, явуулын хяналтын пост 16,000.0 мянган төгрөг, өвс тэжээлийн нөөцийн хашаа 10,000.0 мянган төгрөг, хадлангийн хашаа 20,000.0 мянган төгрөг, контейнер 12,000.0 мянган төгрөг, дотоод интернэтийн сүлжээ сайжруулах тоног төхөөрөмж, цаг бүртгэл, дохиоллын систем 5,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэсэн байна. Мөн 49,961.0 мянган төгрөгийн гэрэлтүүлгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 27 тоот тогтоолоор барилга байгууламжийн данснаас 10,810.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 37,211.0 мянган төгрөг, Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 24-ны №122 тоот тогтоолоор тоног

төхөөрөмж 38,723.2 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 11,984.4 мянган төгрөгийн хөрөнгийг нийт 98,728.6 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад жилийн эцэст олгосон 5,526.7 мянган төгрөгийн шагналын тушаалыг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 98,889.1 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, анхны өртгөө үлдэгдлээрээ бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, худалдан авалт бүрийн е баримт төлбөрийн баримтыг бүрэн баримтжуулах, анхан шатны бүрдэл болсон баримтаар гүйлгээг хийх зэрэг 6 зөвлөмжийг 75,0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 05/26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны тооцоо бодолтыг шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200,962.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 191,033.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,402.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 5,526.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллагын санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төв аймаг 2020 оны үйл ажиллагаагаар "Шилдэг аймаг"-аар шалгарсан гэсэн үндэслэлээр 10 төрийн албан хаагчийг 4,402.0 мянган төгрөгөөр шагнаж, шагналыг цалингийн зардлаас гаргаж төсвийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 тоот тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 "Урамшуулал гэдэгт ... нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 191,033.6 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй ба анхан шатны баримтад хүлээн авсан, өгсөн хүний гарын үсэг, шалгасан нягтлан бодогчийн гарын үсэг бүрэн зурагдаагүй, тамга тэмдэг дарж албажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 "Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ..." гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь дотоод хяналт шалгалтыг төлөвлөж хийгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1-д “Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” хийх гэсэн чиглэлийн дагуу Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдал, шилэн дансны мэдээлэл байршуулсан байдалд хяналт шалгалт хийх

2.1. Илрүүлэлт:

Жилийн эцэст олгосон 5,526.7 мянган төгрөгийн шагналын тушаал шилэн дансанд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж байх

Зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ	4	200,962.3	-	-	1	4,402.0	1	191,033.6	1	5,526.7